

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага зохион байгуулалт:**

Архивын 5 хөмрөгийн 5 дансны 160 хадгаламжийн нэгжийн 9751 хуудас баримтад мастер болон ашиглалтын хувь үүсгэж, тодорхойлон бичилтийг хийж цахим хэлбэрт шилжүүлсэн.

79 хадгаламжийн нэгжээс 193 иргэн 37 байгууллагад архивын баримтын лавлагаа, хуулбар олгох үйлчилгээ үзүүлсэн байна.

2022 оны нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөө, хуваарийн дагуу Мөрөн сумын ЗДТГ, Түнэл сумын ЗДТГ, Галт сумын ЗДТГ, Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ-аас баримтын нөхөн бүрдүүлэл хийж нийт 2016-2020 оны 699 хадгаламжийн нэгжээр Төрийн архивын нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Аймгийн Соёл урлагийн газрын болон Хөвсгөл нуурын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн сургалт өгч нийт 45 албан хаагч хамрагдсан.

**Хоёр . Хууль, эрх зүйн хүрээнд:**

**Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр :**

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Эх үрсийн баяр”-ыг угтан МХЕГ-ын даргын баталсан 2022.01.06-ны өдрийн 01/03 дугаартай “Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжаар аймагт үйл ажиллагаа явуулж буй хүнс үйлдвэрлэлийн 12, хоол үйлдвэрлэлийн 19, худалдаа үйлчилгээний 54, нийт 85 объект хамруулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулан ажиллаа.

**Хяналт шалгалтад хамрагдсан асуудал, шалгалтын явцад хийж гүйцэтгэсэн ажил**

1. Шалгалтын явцад худалдаа үйлчилгээ, хүнс үйлдвэрлэл, хоолны газруудын технологи ажиллагааны горим, ашиглаж буй түүхий эд, боловсруулсан болон худалдан борлуулж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, шошгын мэдээлэл шаардлага хангасан эсэх, гарал үүсэл, баталгаажилтын баримт бичиг, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим

2. Хоол, хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний газруудын ажлын байрны болон ахуйн байр, ажилчдын гар угаах эрүүл ахуйн нөхцөлөөр хангагдсан байдал, угаалга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж буй эсэхийг шалгалаа.

3. Хүнс үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоолны газарт эрүүл ахуйн нөхцөл шаардлага, хоол хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хоол хүнснээс шалтгаалах хордлого

халдвараас урьдчилан сэргийлэх тухай улсын ахлах байцаагчийн 64 заалт бүхий зөвлөмжийг газрын даргын даргын 1/245 тоот албан бичгээр 23 сум, 1 тосгоны нийт 800 гаруй хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

5. Аймгийн Засаг даргын орлогч, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны даргын 2022.05.25-ны өдөр баталсан “Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний тухай удирдамж” –нд тусгагдсаны дагуу Чингүнжавын талбайд худалдаа, үйлчилгээ явуулах нэгдсэн зохион байгуулалтыг хангах, хяналт тавих ажлыг Мөрөн сумын ЗДТГазартай хамтран хийж гүйцэтгэлээ.

Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ

Шалгалтын явцад нийт 291 зөрчил илрүүлж, 185 буюу 63.6% хувийг нь арилгуулж, хоол үйлдвэрлэлийн 1 газарт 18 заалт бүхий албан шаардлага, 64 заалт бүхий 1 зөвлөмж, бүтээгдэхүүнийг хурааж устгах 9 акт гарган хүргүүлж, хүнсний аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцлийг хангуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа.

Шалгалтаар хадгалалтын хугацаа дууссан, чанар байдлаа алдсан 9 ААН, иргэний 72 нэрийн, 21.5 литр, 131.08 кг, 376 ширхэг, 2.171.550 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг устгуулахаар улсын байцаагчийн актаар хураан авч устгалын комисст шилжүүлж, 23 ААН, иргэний 57 нэрийн 20.8 кг, 1.4 литр, 1499 ширхэг, 2.718.650 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг газар дээр нь устган, эрсдэл гарахаас урьдчилан сэргийлж ажиллалаа

#### **Байгаль орчны хяналтын чиглэлээр:**

Хатгал Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Арбулаг сумдад байгаль орчны журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж иргэд ойн мэргэжлийн байгууллагуудад сургалт сурталчилчилгааг хийж ажиллаа.

#### **Хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:**

МХЕГазрын даргын 2022-оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 1/63 удирдамжаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилт, тулгамдаж буй асуудалд тандалт судалгаа хийж байна.

Мөн МХЕГазрын даргын 2022 оны 1/91 дүгээр удирдамжийн хүрээнд туслах малчин, морь унаач хүүхдийн хөдөлмөрийн нөхцөлд хяналт шинжилгээг хийж ажиллаж байна.

Шалгалтаар 110 туслах малчин, 74 морь унаач хүүхдийн хөдөлмөрийн нөхцөлд хяналт шинжилгээ хийсэн.

#### **Онцгой байдлын чиглэлээр:**

#### **Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгаа:**

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэгтэй хамтран Рэнчинлхүмбэ суманд үүссэн шар усны үерийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж холбогдох дүгнэлтийг гаргаж аймгийн Засаг дарга болон шуурхай штабын дарга, орлогч, М.Хуягбаатар нарт танилцуулав.

Улаан-Уул, Мөрөн, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум болон Шунхлай, Магнай трейд ХХК-ний ШТС, Хот тохижилт үйлчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 8 гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянаж батлуулав.

Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө хариуцсан албан хаагчдад 2 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Улс орон даяар явагдсан шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлаар Алаг-Эрдэнэ, Хатгал, Ханх, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр зэрэг сумдад 10 хоног ажиллав.

Нисэх буудлын аюулгүй байдлын хорооны хуралд 1 удаа оролцож холбогдох мэдээллийг солилцов.

Алба хаагчид ЕБС-ийн төгсөлтийн сурагчдын аялал зугаалгын үйл ажиллагааг хорьсонтой холбогдуулж эргүүл постод 3 өдөр 24 цагийн үүрэг гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр баталсан удирдамжын хүрээнд Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг “Жилчиг булаг” ХХК, “Могойн гол ХХК”-ний объектуудад Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч-1, Гал түймрийн улсын хяналтын байцаагч-2 бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулан ажиллав.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/623 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг Эрүүл мэндийг дэмжих төвийн их засварын ажлыг хүлээн авахаар 2022 оны 04 дугаар сарын 28-ны өдөр Улсын комисст орж ажиллав.

Улсын Онцгой комиссын 2022 оны 01 дугаар албан даалгавар Аймгийн Онцгой комиссын 01 дугаар албан даалгаварын хүрээнд Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээг орон нутгийн цахим орчинд тогтмол хүгүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр баталсан удирдамжын хүрээнд Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжид үзлэг шалгалт зохион байгуулж заагдсан зөрчил дутагдалыг арилгуулах Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн Заавал биелүүлэх албан шаардлага-2 бичиж хүргүүлж хяналт тавьж ажиллаж байна.

Шалгалтанд: Мөрөн сум, Тариалан сум, Хатгал тосгон, Цагаан-уул сум, Галт сумдын 2 Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн байгууллага хамрагдлаа. Шалгалтын явцад 29 зөрчил илэрч 6 зөрчлийг үзлэг шалгалтын явцад засуулж, 23 зөрчил дутагдлыг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн Заавал биелүүлэх албан шаардлага-2 бичиж хүргүүлэн биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна. ОБГ-ын ёс журмын эргүүлд 2 удаа гарсан. Ёс зүйн албаны хуралд 2 удаа оролцож давхардсан тоогоор 12 албан хаагчийн сахилгын зөрчлийг авч хэлэлцэж холбогдох хариуцлагыг тооцож ажиллав.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 3/02 дугаар албан бичгийн хүрээнд аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн дарга, төлөөлөлүүд 2022 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдахтай холбогдуулан аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хүргүүлэв.

### **Бэлтгэл бэлэн байдал, гамшигтай тэмцэх үйл ажиллагаа**

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2022 оны 5 сард объектын гал түймэр -7 суманд нийт-6 удаа гарч өвөл, зуны сууц-4, машин техник-1, монгол гэр-4, малын хашаа саравч-4, гал түймэрт өртөж 54,000,000 / тавин дөрвөн сая төгрөг /-ний эд хөрөнгө аварсан, гал түймрийн улмаас 85,000,000 /наян таван сая төгрөг/-ний хохирол учирсан байна. Мөн усны ослын дуудлага 2, усны ослын эрлийг үргэлжлүүлэн хийх хүсэлт 1, барилгын кранын сум хугарсан дуудлага 1, түймрийн дуудлага 1 ирсэн. Дуудлага мэдээллээс товч дурьдвал:

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сум Эрчим 5-р баг Дэлгэрмөрөн гол “Хилэнтийн гүүр” /аймгийн төвөөс урд зүгт 7 км, сумын төвөөс зүүн хойд 44 км-т/ гүүрэн дээрээс Дэлгэрмөрөн

голруу нэг хүн үсэрчлээ гэсэн дуудлагыг 2022.05.06-ны өдрийн 17:49 цагт хүлээн авч ослын дуудлагаар,

Мөрөн сум Урандөш багийн нутаг дэвсгэрт баригдаж буй Мөрөн бетон ХХК 14 давхар "Хоймор таур" барилгын ар талд байрлуулсан 54 мерт өндөртэй барилгын суурин краны сум хугарсан тухай дуудлагыг 2022.05.17-ны өдрийн 20:45 цагт 7038101 утсанд хүлээн авсан. Гурван үгт хаяг: /// онигоо, эрчимт, аяласан// Координат: 49°63'82.5"N100°15'76.4"E,

Бүрэнтогтох сумын Эрчим багийн "Устын ам" гэдэг газар /аймгийн төвөөс баруун урд зүгт 25 км-т, сумын төвөөс зүүн урд зүгт 30 км-т/ ойн түймэр гарсан тухай мэдээг 2022.05.14-ний өдрийн 16:23 цагт хүлээн авсан. 3 үгт хаяг: /// мөдхөн.хурдлах. шинжээчид/// Координат: 49°32'50"N 99°57'51"E,

Их-Уул сумын Сэлэнгэ багийн "Сэлэнгэ мөрний гарам" гэдэг газар /аймгийн төвөөс зүүн зүгт 110 км-т, сумын төвөөс зүүн зүгт 800 метр-т/ тус багийн иргэн Т.Батпүрэв /14 настай, эрэгтэй/ 2022.05.18-ны өдрийн 12:40 цагийн үед усанд осолдсон тухай дуудлагаар,

Түнэл сумын Навчилтай багийн "Улаагчийн өвөр" гэдэг газарт /аймгийн төвөөс зүүн зүгт 90 км-т, сумын төвөөс зүүн хойд хойд зүгт 50 км-т/ тус багийн иргэн Д.Баттөмөр /27 настай, эрэгтэй/, Г.Лхагвадорж /29 настай эрэгтэй/ нар 2022.03.08-ны өдрийн 18:00 цагийн үед шар өнгийн "МУСТАНГ" загварын мотоциклтойгоор /улсын дугааргүй/ сумын төвөөс гэрлүүгээ яваад ор сураггүй алга болсон тухай дуудлагаар тус тус ажиллав.

2022 оны 5-р сарын 18-ны өдөр "Тохиолдож болзошгүй гамшгийн үед Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Онцгой байдлын газартай хамтран ажиллах" төлөвлөгөөний дагуу тус газрын цагдан хорих байр, бусад объектод гал түймэр гарсан үед хамтран авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хоригдогч болон алба хаагчдыг нүүлгэн шилжүүлэх, өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах дадлага сургуулийг хийж ажилласан.

Багаж тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 3 ширхэг царил ирлэж үзүүрэлсэн. 51 мм хоолойны эвхээс сольсон. Байлдааны сүхнүүд ирэлсэн. А,Б хошууг задалж тосолсон. Шилжүүлэн хэрэгсэл гайк,салаа бэлчир, хоолой тотго зэргийг хуурайдаж холбоход хялбар болгосон. Гал унтраах автомашинд 99-10 ХӨА гал унтраах авмомашинны шанзны багажны хөрөө ирлэсэн. 99-10 ХӨА гал унтраах авмомашинны хаалганы түгжээг засварлаж, шанзны багажны хүрзийг ишилсэн. Гал түймэр унтраах аврах ангиудын үндсэн албаны Маз загварын 4 автомашинд тос, масло сольсон.

### **Санхүү, аж ахуйн бодлого зохицуулалт**

Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хуулийн хууль тогтоомж зөрчсөн 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 5.14.1 дахь заалтын дагуу тус бүрд нь 500.000 (Таван зуун мянган) төгрөгийн захиргааны арга хэмжээ авч орон нутгийн орлогод төвлүүлэн ажилласан байна.

Галын аюулгүй байдлын тухай хууль, зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчсөн 4 иргэнийг 100,000 төгрөгөөр нийт-400,000 / дөрвөн зуун мянган төгрөг/-ний торгуулийн арга хэмжээ авч, Галын аюулгүй байдлын тухай хууль, улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1.4 дахь заалтын дагуу 20 аж ахуйн, нэгж байгууллага, 1 шатахуун түгээх станцад ажлын байрны аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгож, барилгын зураг төсөл 1 хянаж орон нутгийн орлогод нийт 352,500 / гурван зуун тавин хоёр мянга таван зуун төгрөг /-ний орлого төвлөрүүлэн ажилласан байна.

Тайлангийн хугацаанд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага-10, мэдэгдэл-12, гал түймэр гарсан тухай акт-4 зэрэг эрх зүйн бичиг баримт үйлдэн ажилласан байна.

2022 оны 05 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны сайт, ил тодын буланд байршуулж удирдлага болон алба хаагч, ард иргэдэд санхүүгийн үнэн зөв мэдээллийг хүргэн ажиллаж байна.

### **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр:**

Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газартай хамтран аймгийн төвийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг “Хөвсгөл”, “Түмний” телевизээр мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор видео контент болон шторкуудыг хүргэж, цагдаагийн газрын эрүү хэв журмын нөхцөл байдлыг 7 хоног бүр мэдээлэл хийж ажиллалаа. Мөн орон нутгийн төсвөөс мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд 3,500,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллаа.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Мал мах” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох суманд зохион байгуулагдсан залуу малчдын зөвлөгөөнд оролцож мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малаа хариулгатай байлгах чиглэлээр сургалт хийж ажиллалаа.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хилийн цэргийн 0257 дугаар анги, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Хүүхэд хамгаалал”, “Сэрэмжлүүлэе” ерөнхий арга хэмжээ, аймаг орон нутгийн хэмжээнд санаачлан зохион байгуулсан “Нэгдүгээрт хүүхэд-Хяналт” хэсэгчилсэн арга хэмжээ, “Хилийн салбаруудад ажиллах” соён гэгээрүүлэх сургалтыг тус тус зохион байгуулж ажиллалаа. Мөн хүүхдийг эрсдэлээс хамгаалах, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эцэг эх, асран хамгаалагчийн хараа хяналтыг сайжруулах чиглэлээр сумдад ажиллах “Бүсчилсэн” сургалтын төлөвлөгөөг “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-оор дэмжүүлэн аймгийн Засаг даргаар батлуулж, уг бүсчилсэн сургалтад зарцуулагдах 5.000.000 төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж ажиллалаа.

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймгийн Засаг даргын 2022 оны А/51 дүгээр захирамжаар шинэчлэн байгууллаа.

2022 оны хагас жилийн байдлаар 2 удаа хуралдаан зохион байгуулж, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээг 42 хүүхдэд үзүүлсэн. Үүнээс гэрч хүүхэд 2, хохирогч хүүхэд 40, гэмт хэрэгт холбогдсон 12 хүүхэд байна. Гэмт хэрэгт холбогдсон болон гэрч, хохирогч нийт хүүхдүүдэд 100% хорооны үйлчилгээг үзүүлсэн бөгөөд хууль ёсны төлөөлөгчөөр 9 удаа, үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээг 7 удаа Гэр бүл, хүүхэд залуучуудын газраас үзүүлж, холбогдох зардлын 3,150,000 төгрөгийг шийдвэрлэж ажиллалаа.

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагааны зардалд 2022 оны эхний хагас жилийн байдлаар 30 сая төгрөгийг шийдвэрлэж ажиллалаа.

2022 оны хагас жилийн байдлаар 6 албан хаагч, 286 хүнд, 1319 удаагийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал үйлчлүүлэгчдийн тоо 10.3%-аар буурч, үйлчлүүлсэн насанд хүрэгчийн тоо өсөж, хүүхдийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 1-6 дугаар ангийн сурагчдын дунд “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээнийг зохион байгуулж 8 сургуулийн 120 хүүхэд хамрагдаж, шагналын сангийн зардлыг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 1.500.000 төгрөг, сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн дунд “Замын

хөдөлгөөний цагаан толгой” зохион байгуулж, тэмцээнд 15 цэцэрлэгийн 120 хүүхэд оролцсон бөгөөд шагналын сангийн 1.000.000 төгрөгийг зардлыг тус бүр шийдвэрлэж хамтран ажиллалаа.

Календарчилсан төлөвлөгөөний дагуу Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж байгаа “Уусан бол бүү жолоод”, “Гэрлээр анхааруулья”, “Гар утас”, “Сурагчийн аюулгүй байдалд асран хамгаалагчийн үүрэг оролцоо”, “Явган зорчигчийн аюулгүй байдал сургууль орчмын бүс” нэгдсэн, болон хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж үр дүнг тооцуулж ажиллалаа.

### **Гурав. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2022 оны 05-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас **11.6** тэрбум төгрөгийн **2145** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2022 оны 05-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 28,582.8 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 27,760.2 сая төгрөг буюу 97.1 % хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2022 оны 05-р сарын мэдээгээр Орон нутгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан 31,290.0 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 1,980.3 сая төгрөг нь татварын бус орлого буюу өөрийн орлогоос, 1,269.2 сая төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй хөрөнгө борлуулсан орлогоос, 8,247.8 сая төгрөг нь аймаг нийслэлээс авсан санхүүжилт, 28,553.2 сая төгрөг нь төсвөөс санхүүжих, 3,613.6 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 10,633.6 сая төгрөг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 31,290.0 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 19,846.5 мянган төгрөг буюу 63.4 % хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **3,842.7** сая төгрөг өмнөх сараас **29.0** сая төгрөгөөр өссөн.

Нийт өглөг **1,728.9** сая төгрөг өмнөх сараас **412.7** сая төгрөгөөр өссөн.

### **Нийгмийн даатгалын хэлтэсийн сарын шуурхай мэдээ:**

2022 оны 05 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлонго 2127.2 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 359.9 сая төгрөгийн, шимтгэлийн орлого 96.8 хувиар биелүүлсэн байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	2363.3	1963.3	83.1
Тэтгэмж	232.7	187.6	80.6
ҮОМШӨ	166.1	116.8	70.3

ЭМД	0,0	0,0	0,0
Ажилгүйдэл	43.9	34.3	78.1
Дүн	2806	2302	78.0

Тэтгэврийн даатгалын сангаас 21114 тэтгэвэр авагчид 10780 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 1065 даатгуулагчдад 277.7 сая төрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 179 даатгуулагчдад 73.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 818.8 сая төгрөг байна.

**Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

**1.ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ЧИГЛЭЛЭЭР**

5 дугаар сард 16 үйл ажиллагаа, үйлчилгээ, сургалт, нөлөөллийн ажилд 1286 хүүхэд, 2473 насанд хүрэгч, 628 гэр бүл, 832 залуучууд хамрагдсан байна.

Газрын фейсбүүк хуудсаар дамжуулан 49 мэдээ мэдээлэл, 6 төрлийн зөвлөмжийг хүргэж нийт 920 хандалт авсан байна.

Газрын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв” нийт 53 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна. 2 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцож, шүүх шинжилгээний дүгнэлт гаргуулж нотлох баримтыг бүрдүүлж ажилласан. Мөн сэтгэл зүйн 2 дүгнэлтийг гаргасан байна. НҮБ-ын хүүхдийн санд үйл ажиллагаагаа танилцуулж ажилласан байна.

Рашаант, Их-Уул суманд ажиллаж, гэр бүлийн боловсрол олгох, амьдрах ухааны чадвар олгох ойлголт мэдээллийг 290 хүнд өгч ажиллалаа.

Онцгой байдлын газрын 235 албан хаагчдад гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, хүүхдийн хүмүүжилд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, оролцоо, хариуцлага, хандлагыг нэмэгдүүлсэн байна. Мөн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүллээ.

Байгууллагын дэргэдэх 13 “Эцэг эхийн зөвлөл” “Гэр бүлийн үнэ цэнэ” нөлөөллийн арга хэмжээнд нэгдэж, нийт 469 гэр бүл эцэг эхийн хамтын хариуцлага, гэр бүлийн харилцаа, гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн төлөвлөлт сэдвээр мэдлэг нэмэгдүүллээ.

Олон улсын Гэр бүлийн өдрийн хүрээнд гэр бүлийн волейболын тэмцээнийг аймагтаа анх удаа санаачлан зохион байгуулж, нийт 24 багийн 183 хүн оролцон гэр бүлийн хамтач харилцаа, харилцан ойлголцлыг дэмжин өрх гэр бүлүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүллээ.

Хөвсгөл аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгч нартай хамтарсан уулзалт зохион байгуулж, гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэхэд хүүхдийн амьдрах, сурах, өсөж торних орчин, эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын хүмүүжилд нөлөөлөх нөлөөлөл зэргийг харгалзан үздэг бөгөөд хүүхдийн эрх, ашиг зөрчигдөж буй эсэхийг тогтоох шинжээчийн багийн ажлыг танилцуулан, 23 сум 1 тосгонд очиж ажиллахад гарах зардлын жагсаалтыг гарган дахин уулзалт зохион байгуулахаар шийдвэрлэв.

7 төрлийн постер, 6 төрлийн видео, 1 удаагийн хичээл, 1 лайваар дамжуулан 7 ерөнхий боловсролын сургууль, 10 цэцэрлэгийн 1743 эцэг, эх, асран хамгаалагчдад хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эсрэг шийтгэлийг таслан зогсоох, гэр бүлийн гишүүдэд цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хүүхдийнхээ хөгжлийг дэмжих, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэхээс татгалзахыг уриалсан мэдээллийг хүргэсэн байна.

Мөрөн суманд даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 7 даатгалын компаниудад зөвшөөрөгдсөн хугацаанд хурдан морины уралдаанч хүүхдийн даатгалыг 100.000 төгрөгөөс доошгүй мөнгөн дүнгээр хийх, хамтран ажиллах чиглэлээ танилцуулан мэдээлэл солилцлоо.

749 хүүхэд, өсвөр үе, залуучууд 6 төрлийн уралдаан, тэмцээнд оролцон авьяас чадвараа хөгжүүлж, түүчээлсэн 102 хүүхдийг шагнаж урамшуулсан байна.

Аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, агентлаг, байгууллагуудын дэргэдэх залуучуудын хөгжлийн зөвлөлийн нийт 62 гишүүн залуучууд чадавхжиж, 10-12-р ангийн 580 хүүхдүүд мэргэжлээ зөв сонгох арга зүйд суралцлаа.

“Хөдөлмөрч Хөвсгөлчүүд” нээлттэй хаалганы өдөрлөгт газрын дэргэдэх Гэр бүлд зөвлөгөө өгөх төв, Залуучуудын хөгжлийн төв болон хүүхдийн ордны дугуйлан хөгжлийн хөтөлбөрийн танилцуулга мэдээллийг иргэдэд өгч, мөн эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлж ажиллаж, нийт 138 хүнд мэдээлэл, зөвлөмж өгч, 11 төрлийн гарын авлага цаасан материалыг тараав.

## **2.БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

Монгол хэл бичгийн анги нийтийн олимпиадын 2 даваанд 32 сургуулийн 9 дүгээр ангийн 82 бүлэг 2270 гаруй хүүхдүүд оролцов.

Эх хэл бидний бахархал -2022 аяны хүрээнд Хөвсгөл аймгийн ахлах ангийн сурагчдад “Цахим орчинд эерэг байя “ сургалт хэлэлцүүлэг, “СҮЕГЭР-2022” уралдааны үзэсгэлэнгийн нээлт, байгууллагын удирдлага, бичиг хэргийн ажилтнуудад болон номын санчдад зориулсан монгол хэл бичгийн сургалт болов

Хөвсгөлийн багш, сурагчид математикийн 58 дугаар олимпиадад аймгаа төлөөлөн оролцсон багш, сурагчид 1 мөнгө, 5 хүрэл медалийн эзэд болж багийн дүнгээр 2-р байр эзэлсэн амжилтыг гаргалаа.

Улсын химийн 31 дүгээр олимпиадад Хөвсгөл аймгийн лаборатори "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн 9 дүгээр ангийн сурагч Б.Алтантуяа гутгаар байр эзэлж, хүрэл медаль хүрлээ.

БШУЯ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс жил бүр уламжлал болон зохион байгуулдаг улсын шилдэг илтгэл шалгаруулах, “багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд “Титэм” ЕБС-ийн сургалтын менежер Б.Түвшинсүх, ТХУ-ы багш Д.Хүрэлбаатар, Г.Төмөрхуяг, М.Ганболд, Б.Оюунцэрэн нарын баг гутгаар байр эзэллээ.

Улсын мэдээлэл зүйн олимпиадад Ирээдүй XXI зуун цогцолбор сургуулийн Д.Батмөнх багш 2-р байр, ЭДЦС-ийн багш О.Жавхлангийн бэлтгэсэн 9-р ангийн сурагч Ш.Пүрэвдаваа тусгай байр эзэллээ.

Улсын физикийн 33-р олимпиадад Хөвсгөл аймгийн лаборатори "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн 9-дүгээр ангийн сурагч Б.ТЭРГЭЛ гутгаар байр эзэлж, ХҮРЭЛ медаль хүртлээ.

Хөвсгөл аймгийн лаборатори “Эрдмийн далай” цогцолбор сургуулийн газарзүйн багш А.САНСАРТУЯА багш улсын олимпиадад 11 удаа оролцож, 5 удаа түрүүлж, 4 удаа 2-р байр, 2 удаа 5-р байр эзэлж байсан ба өнөө жилийн XXVI олимпиадаас АЛТАН медаль хүртлээ.

Олон улсын логик паззлын уралдааны II шатанд ЭДЦС-ийн 11-р ангийн сурагч Х.Цагаанбаатар 2-р байр, ЭДЦС-ийн 9-р ангийн сурагч А.Түмэнбаяр 2-р байр, ДМЦС-ийн 7-р ангийн сурагч Ц.Намуунаа 3-р байр тус тус эзэллээ.

Нийгмийн ухааны улсын XXIV олимпиад Орхон аймгийн Эрдэнэт хотноо зохион байгуулагдаж, лаборатори "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн 12 дугаар ангийн сурагч Б.Энхзул дэд байранд шалгарч мөнгөн медаль хүртлээ.



Түүхийн улсын XXIV олимпиад Улаанбаатар хотноо болж, багш нарын ангилалд Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн Түүх, нийгмийн ухааны багш Б.Банзрагч тэргүүн байр эзэлж, алтан медаль хүртлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, тэвчээр хатуужил олгох, Зэвсэгт хүчний залгамж халааг бэлтгэх зорилгоор Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны А/102 дугаар захирамжаар цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний хоёрдугаар шатны шалгаруулалтыг зохион байгууллаа.

БШУЯ, БЕГ, Хөвсгөл аймгийн ЗДТГ, БШУГ хамтран "Боловсролын салбарын төсвийн шинэчлэл" сэдэвт уулзалт сургалтыг зохион байгуулж БШУЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягтцогтоор ахлуулсан баг бүрэлдэхүүн Хөвсгөл аймагт ажилласан байна. Сургалтад ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, багш, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, нягтлан бодогч нийт 301 хүн танхимаар, бусад багш, ажилтнууд цахимаар оролцож мэдээлэл авч, дадлага ажил хийж мэдлэг туршлагаа солилцов.

### **3.ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Орон даяар эхлүүлж буй Эрүүл мэнд үндэсний баялаг эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж төр хувийн хэвшил, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтайгаа цахимаар холбогдон үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, цаашид анхаарах асуудлууд сэдвээр арга зүйн зөвөлгөөг чиглэл тус бүрээр өгч ажиллаа. Мөн энэ үеэр Эрүүл мэдийг дэмжих төвийн үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлах зорилгоор лайв байдлаар нийт эрүүл мэндийн байгууллагын эмч ажилчид, орон нутгийн телевизээр иргэдэд шууд дамжуулан хүргэлээ. Улмаар нэгдсэн хүн амыг урьчилан сэргийлэх, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллааны нээлтийн арга хэмжээ НЭМҮТ, Focus,mn хамтран хийсэн лайвт оролцож, нээлтийн үйл ажиллагаа болон эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн эхлэлийн талаар мэдээлэл өгч хамтран ажиллаа.

“Сэтгэл зүйн эрүүл мэнд хамтын оролцоо” сургалтыг аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, нэгдсэн эмнэлэг хамтран зохион байгуулж, Мөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэлзүйч нар оролцов.

Уг сургалтаар сургуулийн сэтгэл зүйч нарын ажлын байрны тулгамдаж буй асуудал, Сэтгэл зүйч мэргэжлийн ажлын байрны онцлог, “Хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зураглал батлах тухай” Эрүүл мэндийн сайдын А/779 тушаалийг тус тус танилцуулж мэдлэг мэдээлэл олголоо. Манай аймгийн хувьд Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор, Эрдмийн далай, Гурван Эрдэнэ, Титэм, Авъяас сургуулиуд, Рашаант, Төмөрбулаг, Хатгал зэрэг сумдад сэтгэлзүйч ажиллаж байна.

ДЭМБ, АИФО байгууллагаас зохион байгуулсан “Эрүүл мэндийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй байлгах ДЭМБ-ын аргачлал” сургалтад 2 сургагч багш бэлтгэгдсэн. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ”-г үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулах зорилгоор сургалт зохион байгууллаа. Сургалтад Нэгдсэн эмнэлгийн чанарын менежер, мэдрэл, гэмтэл мэс засал, хүүхэд, сэргээн засал, уламжлалтын тасгийн их эмч нар, “Энх-Үйлс”, “Далайн-Элбэрэлт” ӨЭМТ-ийн бага эмч, ахлах сувилагч, “Мөнхтулгуур” эмнэлгийн менежер, ахлах сувилагч, Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн бүртгэл мэдээллийн ажилтан зэрэг нийт 12 хүн хамрагдлаа. Сургалтыг нээж АИФО-ийн суурин төлөөлөгч, ДЭМБ-ын зөвлөх Д.Тулгамаа цахимаар оролцлоо.

Сургалтын төгсгөлд Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн хүлээн авах, эрэмбэлэн ангилалт яаралтай тусламжийн хэсэг, мэдрэл, хүүхдийн тасгуудад 4 хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийн дүрд тоглуулж, яаралтай тусламжийн тасагт хяналтын хуудсаар бие бялдрын хүртээмжийн аудит хийх дадлага хийн, дадлагын дараа хүртээмжтэй орчин бүрдсэн эсэх талаар ярилцлага хийж, сургалтын үр дүнг хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /400 сая төгрөг/ Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжүүлэхээр боллоо. Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 40 багийн эмчийн мотоцикл, 4 сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн шүдний тоног төхөөрөмж, Улаан-Уул сумын Эрүүл мэндийн төвд зөөврийн рентген аппарат болон статистикч, дүн бүртгэгч эмч нарт 30 компьютер, 30 принтерийн асуудлыг шийдвэрлэлээ. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд Далай тойрсон 8 суманд “Багийн эмч нарыг унаажуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн ба бүх багийн эмч нарыг шинэ мотоциклтой болгосон. Энэ онд 40 багийн эмч нарыг унаажуулж байна.

Хөдөө орон нутагт хамгийн тулгамдаж байгаа асуудлын нэг бол шүдний өвчлөлийн асуудал ба “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Улаан-Уул, Тариалан, Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн шүдний тоног төхөөрөмжийг шийдвэрлэлээ. Түүнчлэн, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумын 12000 гаруй иргэдэд яаралтай болон түргэн тусламжийг газар дээр нь үзүүлэхэд нэн шаардлагатай байгаа зөөврийн рентген аппаратыг Улаан-Уул сумын Эрүүл мэндийн төвд шийдвэрлэн өгч байна. Мөн Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвөөс тавьсан хүсэлтийг Эрүүл мэндийн яаманд уламжлаж зөөврийн рентген аппарат шийдвэрлүүлэн хүлээлгэн өгсөн.

Хачигт халдварын байгалийн голомтын хайгуул шинжилгээг Эрдэнэбулган, Тариалан сумдын 24 секторын 86 цэгт газарт хийж D.nuttallii зүйлийн 4348 хачиг, 8 цэгт газраас I.persulcatus зүйлийн 33 хачиг цуглуулан хачигт халдварын үүсгэгч илрүүлэх шинжилгээнд хамруулахаар хүргүүлээ. Энэ удаагийн судалгаагаар ойн хачгийн(I.persulcatus) тархалттай 8 цэгт газрыг шинээр илрүүлэн, дээж цуглууллаа. Мөн 3 сумын ЭМТ-ийн бэлэн байдалд хяналт үнэлгээ хийн зөвлөн тусалж, 181 өрхийн 703 хүн амд ЗХӨ-нөөс сэргийлэх яриа хийж, 500 хүнээс хачгаар дамжих халдварын асуумж судалгааг авлаа.

#### **4.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР**

WAIS программаар 2022 оны 5 дугаар сард 6303 иргэнд 147,1 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг олгосон.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ehalamj.mn-ээр 14490 иргэнд 1.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон.

2022 оны 5 дугаар сард 357 иргэн ажилд зуучлагдсан, идэвхтэй ажил хайгчаар **465** иргэн, Шинээр 596 бий болсон бөгөөд байнгын 459 ажлын байр түр 137 бий болсон

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт хамрагдахаар 245 иргэн төслөө ирүүлсэн бөгөөд төслийг сонгон шалгаруулах ажлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс хэлэлцэж сонгон шалгаруулалт хийнэ. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Оролцоо” төсөлд хамрагдахаар аймгийн хэмжээнд 16 иргэн бүртгүүлэн төсөлд харагдахаар шийдвэрлэгдсэн.

Халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтний сул ажлын байрны захиалгыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны тухай хуулийн дагуу 2021 оны 3 дугаар сард 3 албан хаагчийг сэлгэн ажиллуулсан бөгөөд сэлгэн ажиллуулсан хугацаа дууссан тул үндсэн ажлын байранд нь эгүүлэн томилсон.

Ахмадын амралтын газрын үйл ажиллагааг эрчимжүүлэн нэг ээлжиндээ 40-95 ахмад настан амарч хөнгөлөлт эдлэж байна. Үүний хүрээнд ахмадын амралтын газарт 6 гэрээт ажилтан шинээр ажилд авсан.

## **5.БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

“ Илүүдэл жингүй-Эртэч монгол ” аяны хүрээнд “Илүүдэл жингүй-Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяныг аймгийн хэмжээнд 2022 оны 3 дугаар сарын 21-нээс 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл зохион байгуулж байна. Аяны хүрээнд Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Ар булаг, Цагааннуур, Ренчинлхүмбэ, Баянзүрх, Улаан-Уул сумдад ажиллалаа. Сумдууд Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан үйл ажиллагаагаа зохион байгуулан, хөтөлбөрөө болосруулан ажиллаж эхэлсэн байна.

Үйл ажиллагааны хүрээнд сумд 7 хоногийн 2 өдрийг бүжгийн спортоор хичээллэх өдөр болгон зарлаж, спортын тэмцээнүүдийг төрийн албан хаагчдынхаа дунд зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

“Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хаалтын үйл ажиллагаа 2022 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хотгойдын Шадарван Чингүнжавын талбайд өглөөний 06:30 цагт боллоо. Хаалтын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч, иргэд нийт 5000 гаруй хүн оролцлоо. Энэхүү арга хэмжээ нь 2022 оны 2 дугаар сарын 16-наас 2022 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хүртэл 73 өдрийн хичээлийг улс орон даяар цахим хэлбэрээр явуулахад Хөвсгөл аймгийн 24 сумын спортын 38 заал, фитнес клуб-3, соёлын төв-8, гадаад талбай-67, спорт болон бүжгийн холбоод-18, ахмадын болон чийрэгжүүлэх танхимууд-48, танхимаар болон цахимаар гүйж, алхаж, дугуй унаж, ууланд алхаж идэвхтэй хөдөлгөөн хийсэн иргэд 170.000 гаруй иргэд хамрагдсан байна.

“Илүүдэл Жингүй-Эртэч Монгол” аяны шагнал гардуулах үйл ажиллагааг Биеийн тамир спортын газар зохион байгуулж арга хэмжээнд амжилттай оролцсон албан байгуулага аж ахуй нэгж, иргэдийг шагнаж урамшууллаа.

Хөнгөн атлетикийн улсын аварга шалгаруулах өсвөрийн тэмцээн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт зохион байгуулагдаж 8 тамирчин оролцсоноос П.Бямба-Очир нь бөөрөнцөг түлхэлтийн төрөлд Улсын аваргын мөнгөн медаль хүртлээ. Хүндийн өргөлтийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн Хэнтий аймгийн Дадал суманд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Хөвсгөл аймгаас нийт 8 тамирчин оролцож 10 алт, 8 мөнгөн медалийн болзол хангалаа. МБАТС-ын 15 дугаар их наадмын жүдо бөхийн тэмцээн Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, 21 аймаг, 9 дүүргээс шалгарсан 200 гаруй тамирчин 14 жинд барилдсанаас +100 кг-ын жинд ОУХМ А.Давааням алтан медаль, 48 кг-ын жинд ОУХМ Б.Баасанхүү мөнгөн медаль, 57 кг-ын жинд СМ О.Оюунчимэг хүрэл медаль хүртэж, багийн нийлбэр дүнгээр 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль хүртлээ. Тус тэмцээнд Хөвсгөл аймгаас 1 дасгалжуулагч 9 тамирчин оролцлоо. Жүдо бөхийн 2022 оны улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, Хөвсгөл аймгийн баг 49 тамирчин, 6 багшийн хамт оролцож, 2 алт 3 мөнгө 5 хүрэл нийт 10 медаль авч багийн дүнгээр 3 дугаар байр эзэлсэн амжилт гаргалаа. Мөн медальт байранд 10 тамирчин шалгарч хүрэл медаль, цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав.

U15, U20 Чөлөөт бөхийн өсвөр залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж Хөвсгөл аймгаас өсвөрт U15-д нийт 7 тамирчин U20-д 5 тамирчин оролцсон. U15-д 2 алт, 2 мөнгөн медаль, U20-д 1 мөнгөн медаль хүртэн амжилттай оролцлоо. U17 Чөлөөт бөхийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 20 гаруй тамирчин оролцож 5 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцлоо.

Хөвсгөл аймгийн Дугуйн холбоо нь аялалын бямба гариг клубтэй хамтран “Илүүдэл жингүй-Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны хүрээнд Даль цэцэглэх цагаар Хаврын баярт

зориулсан 230 км аялалыг 15 хүний бүрэлдэхүүнтэй Эрдэнэнбулган суманд зохион байгууллаа.

Хөвсгөл аймгийн Насанд хүрэгчдийн ААШ-лах “Зуун буудалт даам”-ны тэмцээн зохион байгуулагдаж эрэгтэй 18, эмэгтэй 16 тамирчин оролцож авхаалж самбаа, ур чадвараа сорин өрсөлдлөө.

### **Зургаа мал аж ахуй, газар тариалан, хаваржилтийн талаар:**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Дархад омгийн адуу үүлдрээр батлуулах судалгааны ажлыг гүйцэтгэхээр шалгарсан “Ак арал” ХХК, Хогорын монгол үхрийг омгоор батлуулах судалгааны ажил, хянан магадалгаа хийх ажил нийлүүлэх гэрээг “Экологи технологи хөгжлийн төв” НҮТББ-ын захирал Т.Ариунболдтой тус тус хийсэн.

Засаг даргын 2022 оны “Шинэ хөдөө төслийн үйл ажиллагааны жагсаалт, төсвийн хуваарь батлах тухай” А/33 дугаар захирамжийн 01 дүгээр хавсралтын 1, 2, 3 дугаар хэсгийн жагсаалтын төсөвт өөрчлөлт оруулж Засаг даргын захирамжийг өөрчиллөө.

Аймгийн хэмжээнд 23 сум 1 тосгоноос мал төллөлт, малын зүй бус хорогдлын явцын мэдээг 7 хоног бүрийн пүрэв гариг, эцсийн мэдээг авч нэгтгэн "Малыг ялган тэмдэглэх, бүртгэх системд мал төллөлт, төл бойжилтын мэдээг программд оруулсан. 2022 оны 05 сарын 26-ний байдлаар: Мал төллөлт оны эхний 2632722 толгой хээлтэгч мал төллөхөөс нийт 1525097 толгой хээлтэгч төллөсөн үүнээс ингэ 132, гүү 34605, үнээ 84174, эм хонь 847347, эм ямаа 558839 мал төллөж байна. Хээл хаясан хээлтэгч нийт 2953 толгой. Төлөлтийн хувь 66.0 хувьтай, төл бойжилт 98 хувьтай байна. Мал төллөлтийн хувь хамгийн өндөр байгаа сум Мөрөн-90.7%, Цагаан-уул-90.2%, Цэцэрлэг-80.9%-тай төллөж байна.

Оны эхний 5943214 толгой том малаас нийт 11461 толгой хорогдсон байна. үүнээс: адуу 565, үхэр 1224, хонь 5129, ямаа 4543 мал хорогдож оны эхний нийт малаас 0.18 хувь нь хорогдсон байна. 2021 оны оны 5 сарын 26-ний өдрийн мэдээтэй харьцуулахад: Мал төллөлт 11.3 хувиар бага, төл малын хорогдол-6917 толгойгоор нэмэгдсэн байна. Том малын зүй бус хорогдол 44.8 хувиар буурсан байна. Хөдөө аж ахуйн салбарын ажлыг эрчимжүүлэх тухай 04 албан даалгавар гаргав. Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Малын генетик нөөцийн хэлтэст хагас жилийн бичмэл болон хүснэгтэн тайланг гаргаж хүргүүлсэн.

2022 оны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”-ийн хагас жилд хэрэгжүүлсэн ажлын товч тайланг 5 дугаар сарын 19-ны байдлаар гаргаж аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. “Хөдөлмөрч-Хөвсгөлчүүд” төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр”-т ажлын хамт олноор оролцож салбарын ажлаа сурталчлан мал бүртгэлжүүлэлтийн ажлын ач холбогдлын гарын авлага материалыг 25 ширхгийн малчдад таарсан. Мөрөн сумын 25 малчдыг зөвлөгөөнд бүрэн хамруулж ажилласан.

Бүрэнтогтох суманд 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан “Буянт сүргийн эзэд” малчдын зөвлөгөөнд оролцож аймгийн хэмжээнд “Мал аж ахуйн чиглэлээр баримталж буй бодлого, цаашдын чиг хандлага” сэдвээр сургалт хийсэн. Сургалтад 150 малчин оролцсон. “Гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын хэрэгжилт” сэдэвт сургалтад 2022 оны 05 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд Улаанбаатар хотод хамрагдсан.

Мөрөн, Эрдэнэбулган Рашаант, Тосонцэнгэл сумууд Хоршоо хөгжүүлэх сангийн төслөө хүлээн авч сонгон шалгаруулсан. Нийт 14 төсөлд 481.5 сая.төгрөгийн зээл олгогдохоор шийдвэрлэгдсэн байна. Аймгийн “Ахуй үйлчилгээний салбары хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн үс засах үйлчилгээний MNS 5160-2020 стандарт-ын 9.3 заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Лонда ПС” ХХК-ны дэргэдэх “Лонда” үсчин гоо сайханчдыг мэргэшүүлэх сургалтын төвөөс чадавхжуулах сургалтыг 2022.05.04-ны өдөр соёмбо танхимд зохион байгуулагдаж сургалтад 5 сумын 98 үсчин гоо сайханчдыг хамрууллаа.

Төв хангайн бүсийн Улсын аварга шалгаруулах үсчин гоо сайханчдын тэмцээнд оролцогчдод Засаг даргын нөөц хөрөнгөөс 1200,000 төгрөгний дэмжлэг үзүүлснээр Гоо сайханч О.Оюунбилэг 1-р байр "Гоо мөрөн" салоны үсчин Б.Нямгэрэл 1-р байр "Гоо даль" салон үсчин Д.Мөнхнасан 2-р байр, 3-р байр, тусгай байр аймгийн үсчин гоо сайханчид амжилттай оролцож "ТЭРГҮҮН БАЙР" "ГРАНПРИ" цомийн эзэн боллоо.

Хүнс, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Тохирлын гэрчилгээ" олгох, хугацааг сунгах, хүчингүй болгох, шийдвэр гаргах баталгаажуулалтын зөвлөлийн бүрэлдэхүүн хуралдаж Мөрөн сумын 18, Тосонцэнгэл сум 16, Рашаант сум 13, Их-Уул сум 7, Эрдэнэбулган сум 11, Ханх сум 5, Түнэл сум 1, Алаг-Эрдэнэ сум 3 аж ахуй нэгж байгууллага тохирлын үнэлгээнд хамрагдаж холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шалгуур үзүүлэлтийн дагуу шинжээчийн дүгнэлтийг үндэслэн хэлэлцэж 74 тохирлын гэрчилгээ олгох шийдвэр гаргалаа.

Хөвсгөл аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо нь Аймгийн Засаг Даргын Тамгын газар, Хүнс Хөдөө Аж Ахуй газар, Мөрөн сумын тамгын газартай хамтарч Төвийн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн ур чадварын уралдаан, “Супер тогооч” урлаг спортын наадам нь 2022 оны 5 дугаар сарын 26-29 ны өдрүүдэд Эрдэнэт хотод явагдаж манай аймгаас 14 тогооч оролцлоо.Энэ үйл ажиллагааг дэмжиж Засаг даргын нөөц хөрөнгөөс 1000,000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн. 5 дугаар сарын 14-аас 16-ны өдрүүдэд Эрдэнэбулганд суманд Зүүн бүсийн сумдыг хамарсан “Мөнгөн мод-Бизнес эрхлэгчдийн уулзалт” арга хэмжээ амжилттай зохион байгуулагдаж Их-Уул, Тосонцэнгэл, Чандмань-Өндөр, Цагаар-Үүр сумдын 100 гаруй бизнес эрхлэгчид оролцлоо.

Газар тариалангийн чиглэлээр:

Энэ онд 17981 га-д үр тариа, 351 га-д төмс, 228 га-д хүнсний ногоо, 1120 га-д малын тэжээл, 400 га-д тосны ургамал, 120 га-д жимс жимсгэнэ, нийт 20200 га талбайд тариалалт хийхээр төлөвлөж хураалтын дүнгээр 22111 тонн үр тариа, 3600 тонн төмс, 2616 тонн хүнсний ногоо, 2600 тонн малын тэжээл, 200 тонн тосны ургамал, 45 тонн жимс, жимсгэнэ тус тус хураан авах 13600 га-д уриншийн боловсруулалт хийхээр зорилт дэвшүүлэн хаврын тариалалтад 73 аж ахуйн нэгж 597 иргэн ажилдаа орж үр тариа 16529 га талбайд, төмс хүнсний ногоо 247 га талбайд тариалалт хийж явц 95%-тай байна.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)-ын даргын А/187 дугаар тушаалаар баталсан “Шүлхий өвчинтэй тэмцэх заавар”, Улсын онцгой комисс (УОК)-ын 02 дугаар тогтоол, УОК-ын шуурхай штабын 2022 оны 3-р сарын 28-ны өдрийн 330, МЭЕГ-ын даргын 2022 оны 3-р сарын 3-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай”, 2022 оны 4-р сарын 8-ны өдрийн А/77 дугаар тушаал “Шүлхийн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай”, Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион

байгуулах Стандарт Ажиллагааны Зааварчилгаа (САЗ), Аймгийн засаг даргын 2022 оны 4-р сарын 14-ын өдрийн “Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/117 дугаар захирамж, Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах ажлын удирдамж, МЭЕГ-ын даргын 2022 оны 4-р сарын 15-ны өдрийн А/08 тоот тушаалын дагуу шүлхий өвчний дархлаажуулалтын ажлыг 2022 оны 4-р сарын 18-ны өдөр Хөвсгөл аймгийн хэмжээнд эхлээд байна.

2022 оны 4-р сарын 11-ны өдөр МЭЕГ-аас ОХУ-д үйлдвэрлэсэн Шүлхийн өвчний А, О дэд хэвшлийн СТО 050222 цувралын дугаартай 532,0 мянган тун 436470,3 сая төгрөгийн вакцин нийлүүлэгдэж вакцины тэмдэглэгээний код болох 20-01-ээс 20-23 хүртэл дугаарласны дагуу 23 сум, 1 тосгоны 74 аж ахуйн нэгжид хуваарийн дагуу хөргүүртэй машинаар түгээлт хийн зориулалтын хөргүүрт нь хийсэн. Вакцин түгээлтийн ажил 4-р сарын 17-ны өдөр дуусч, уг ажилд 23 сум 1 тосгны 125 багт ажлын 105 хэсэгт 594 хүн ажиллаж байна. Үүнд удирдах ажилтан - 129, малын эмч - 121, техникч - 51, туслах ажилтан буюу мал баригч - 204, жолооч - 94 байна. Аймгийн хэмжээнд нийт 504,5 мянган толгой үхэр, 2448 толгой цаа буга, 534 толгой гахай таригдахаас өнөөдрийн байдлаар 14091 өрхийн 476756 үхэр, 512 гахайг, цаа буга 2140 нийт 476756 толгой мал, амьтан хамрагдаж нийт малын 94 хувийг вакцинжуулалтанд хамруулаад байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 04-р сарын 15-ны А/89 тоот тушаалын дагуу арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/80 тоот “Ариутгал, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажил зохион байгуулах тухай” захирамж, халдваргүйжүүлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 6406:2013 стандартыг тус 23 сум, 1 тосгоны Мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн аж ахуйн нэгүүдэд хүргүүлэн ажиллаа. Дээрх эрх зүйн актуудын дагуу сумдуудын засаг даргаар захирамж, төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 13718 мянган том малын зүй бус хорогдол гарсны 11456ш сэг зэм буюу 83.5 хувь цуглуулж устган халдваргүйтгэл хийгдэж байна. Үүнд: -Нийтийн эзэмшлийн талбай-2135м<sup>2</sup>, Хашаа хороо – 669100м<sup>2</sup>, Өтөг бууц – 197120м<sup>2</sup>, Худаг уст цэг – 3910м<sup>2</sup>, Бэлчээр – 17996м<sup>2</sup>, Зоорь – 6852м<sup>2</sup> Устгалын цэг – 4890м<sup>2</sup> Нийт 902003 м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийгдэж байна. Дээрхи ажлыг зохион байгуулахад мэргэжил, аргазүйн удирдлагаар хагаж, зөвлөгөө, зөвлөмж өгч хамтран ажиллаж байна.

### **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР:**

“БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ” сарын аяны төлөвлөгөөний хүрээнд сумдад зөвлөмж чиглэл өгч хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд ахуйн зориулалтаар загас барих зөвшөөрлийг e\_zagas.mn цахим системд оруулахтай холбоотой танилцуулга цахим сургалтанд оролцож шаардлагатай нэмэлт мэдээллийг гаргаж хүргүүлсэн.

Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөний санал авах хэлэлцүүлгийн сургалтад цахимаар болон танхимаар тус бүр 2 удаа оролцсон.

2022 онд ахуйн зориулалтаар ан агнах, барих дээд хязгаарыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Цагааннуур суманд загас үржүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг хүлээн авсан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/120 дугаартай “Ажил зохион байгуулах тухай” захирамж, Мөрөн сумын Засаг даргын А/76 дугаартай захирамжийн дагуу 2022.05.06-ны өдөр Бүх нийтийн цэвэрлэгээ, Орчны цэвэрлэгээг зохион байгуулж холбогдох тайлан болон “Зүгээр битгий хая-Хогоо ангилъя” аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг боловсруулан илгээсэн. Мөн сумдаас бүх нийтийн цэвэрлэгээнд оролцсон тайланг авч нэгтгэж байна. Мөрөн сумын ЗДТГ-аас зохион байгуулж буй “Зүгээр битгий хая-хогоо ангилъя” аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хөвсгөл нуур -Эгийн голын сав газрын захиргаа, Дэлгэрмөрөн, Шишхэд голын сав газрын захиргаа, Дэлгэрмөрөн сум дундын ойн ангитай хамтран баталсан.

Уг аяны хүрээнд Хог хаягдлын тухай хууль, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2019 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам, аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хог хаягдлын талаарх мэдээллийг ажилтан албан хаагчиддаа танилцуулсан. 5 дугаар сарын 30-31-нд зохион байгуулагдах “Уур амьсгалын өөрчлөлт ба Хот” чуулганд хотуудын хариуцан хэрэгжүүлж буй сайн туршлагыг олон нийтэд сурталчилах, хоорондоо туршлагаа солилцох хүрээнд “Хоггүй Мөрөн хот” видео танилцуулгыг аймгийн ЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн албатай хамтран бэлтгэлээ.

Эрдэнэбулган сумын хогийн цэгийг шинээр байгуулах, хуучин хогийн цэгт техникийн нөхөн сэргээлт хийх, хяналтын цооног байгуулах, далан барих ажлын санхүүжилт хүрэлцэхгүй болсон тул Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 100.0 сая төгрөгний нэмэлт санхүүжилт хүссэн албан бичиг илгээж 50.0 сая төгрөгний санхүүжилт олгохоор болсон. Мөн явцын гүйцэтгэлийн тайланг гаргасан.

ООР ГРУПП ХХК-ийн авто засвар, ИХ ТАЙГА ХХК-ийн цайны үйлдвэр, М.Одгаригийн авто угаалгын газарт, үйл ажиллагаанд байгаль орчны ерөнхий үнэлгээ хийсэн.

Аймгийн ИТХ-аас 2023 оныг “Хөвсгөлд зочлох жил” -ээр зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын 05 дугаар сарын 23-ны “Хөрөнгө зарцуулах тухай” А/169 захирамжаар “Улаанбаатар тревэл экспо 2022” аялал жуулчлалын үзэсгэлэнд 6,600,000 төгрөгийг үзэсгэлэнгийн бэлтгэл ажил хангах, сурталчилгаа хийж оролцоход зорцуулахаар шийдвэрлүүлсэн. Энэ дагуу “Хөвсгөлд аялах паспорт”-ын эхийг бэлтгэж 500 ширхэг, аяллын маршрут, түүх соёл, байгалийн үзэсгэлэнт газруудын зураг бүхий мэдээллийг 1х2м-ийн хэмжээтэй 12 стэнд хэвлүүлж, видео сурталчилгаа хийхэд зориулж 65 инчийн дэлгэц худалдан авсан.

Улаанбаатар тревэл экспо 2022 үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн 2022 оны 05 дугаар сарын 27-29 ны өдөр зохион байгуулагдаж аймгийн ЗДТГ, БОАЖГ, Соёл Урлагийн газар, Хөгжимт драмын театр, Аялал жуулчлал эрхлэгчдийн холбоо, Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний холбоо, гар урлал эрхлэгчид оролцож нийт 30м2 талбайг тохижуулан сурталчилгаа хийлээ. Үзэсгэлэнд аймгийн аялал жуулчлалын 5 маршрут, байгаль түүх соёлын үзэсгэлэнт газруудын мэдээлэл, эвент арга хэмжээ, аялал жуулчлалын байгууллагуудын мэдээллийг бэлтгэн дэлгэн тавьж сурталчилсан. Мөн аймгийн ХДТ ардын урлагийн тоглолт зохион байгуулж, Дэлгэр ресорт жуулчны бааз үзэсгэлэнг ирж сонирхогчдын дунд хөгжөөнт тоглоом зохион байгуулж ялагчийг хөнгөлөлттэй амрах эрхийн бичгээр шагнаж урамшууллаа

Аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссын референт Ө.Цэрэнпагматай хамтран “Хөдөлмөрлөх эрх ба, хөдөлмөрийн хүрээний зарим асуудал”, “Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт” гэсэн 2 сэдвээр БОАЖГ, Дэлгэр мөрөн Шишхэд голын сав газрын захиргаа, Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргаа, Дэлгэрмөрөн Сум дундын ойн ангийн ажилтнуудад мэдээлэл өгч, дадлага ажил хийлээ. Улсын төсвийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Рэнчинлхүмбэ сумын “Хоногцол”-д отоглох цэг байгуулахаар тендер зарлаж Тод горхи компани шалгарч тухайн ажлыг гүйцэтгэхээр боллоо. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил 2022 нэрлэсэн жилийн хүрээнд зохион байгуулагдсан төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрт оролцов. Гэгээ авто угаалгад ус ашиглах дүгнэлт гаргаж хүргүүлэв. БОАЖСайдын албан бичгээр ирсэн чиглэлийн дагуу 2022 онд усны чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан аймгийн ЗДТГ-т хүргүүлэв. Түнэл сумын Хөхөөн түрүүнд ус хуримтлуулах жижиг хөв цөөрөм байгуулсан ажлын гүйцэтгэлийг ажлын хэсэг хүлээн авав.

Усны тоолууржилтын судалгааг гаргаж Усны газарт хүргүүлэв. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Гэгээ авто угаалга, Тана авто угаалга, Оргил ХҮТ, Хөвсгөл төсөл ХХК тулгуурын үйлдвэр, Тогтвортой аялал жуулчлал төсөл усны хэрэглээгээ тоолууржуулав. Тогтвортой хөгжлийн боловсрол II төсөл хэрэгжиж буй 5 сургуулийн тайлан, үзэсгэлэн 5 сарын 25-нд болов.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах журмын сургагч багш бэлтгэх сургалтад 3 мэргэжилтэн хамрагдав. Прокурорын газарт Сэлэнгэ мөрний тухай мэдээллийг хүргүүлэв.

БОАЖЯамнаас зохион байгуулсан “Мод тарих 1000 сургагч багш бэлтгэх” цахим сургалтанд бүх сумдаас нийт 69 хүн хамрагдав. Эдгээр сургалтанд хамрагдсан хүмүүсийн хээрийн сургалтыг 06-р сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон суварга босгоё” аяны хүрээнд 2022 оны хаврын “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр нийт 42823 ширхэг мод бут, сөөг таригдсан. Үүнээс 26251 ширхэг мод, 16572 ширхэг бут сөөг таригдсан байна. Шинээр байгуулагдсан бичил цэцэрлэг, ногоон байгууламжийн талбай хэмжээ 6.72 га, 2860м<sup>2</sup> талбайд зүлэгжүүлэлт, 43м<sup>2</sup> талбайд цэцгийн мандал байгуулагдсан. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр нийт 435 аж ахуйн нэгж байгууллага оролцож, 27353 иргэд идэвхтэй оролцлоо.

Хаврын мод тарих өдөртэй холбогдуулан тарьсан модыг хэрхэн арчлах, ургуулах талаар зөвлөмжийг эрх чөлөө сонинд хэвлүүлэн гаргав. БОАЖГ-ын Төмөртэйн мод үржүүлгийн газарт тарих хайлаас модны үр түүх ажлыг Их-Уул сумаас түүж бэлтгэн, тарилтын ажлыг зохион байгуулан ажилласан. Улиасны 5000 ширхэг мөчрийг 2х25 хэмжээтэй 4 даланд, 1х8 хэмжээтэй 5 даланд хайлаасны 15кг үр, 4х10 хэмжээтэй 2 хүлэмжинд шинэсний үрийг тус тус тарьсан.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН



АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА